



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26-75-33

Цахим шуудан: info@mojha.gov.mn

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.05.21

№

1/2780.

танай

-ны №

-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Т.МӨНХСАЙХАН ТАНАА**

“Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/189 дүгээр тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянаад захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ~~4260~~ дугаарт бүртгэн хүргүүлэв.



Хууль зүй, дотоод хэргийн яам

Удирдлага

Сайд

Оюунсайхан Алтангэрэл

2025.05.22 16:03


- 3.1.2 эмнэлгийн барилгын гадна талбайн тохижилт хийх;
- 3.1.3 эмнэлгийн хэрэгслээр хангах;
- 3.1.4 эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах;
- 3.1.5 эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг сайжруулах;
- 3.1.6 эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээг сайжруулах;
- 3.1.7 нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг дэмжих;
- 3.1.8 судалгаа боловсруулалт, технологи, инновацыг сайжруулах;

Дөрөв. Бусад

4.1. Аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.9 дэх хэсгийг татвараас зайлсхийх үндсэн зорилгоор ашигласан нь тогтоогдсон тохиолдолд татварын хуульд заасны дагуу хөнгөлөлт эдлүүлэх үндэслэл болохгүй.

4.2. Аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулагдаагүй, гэрээний хэрэгжилт хангагдаагүй нь тогтоогдсон тохиолдолд татварын хуульд заасны дагуу хөнгөлөлт эдлүүлэх үндэслэл болохгүй.

--- оОо ---





МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 05 сарын 21-ны
өдрийн 7260 дугаарт бүртгэв.

2025 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 2/189

Улаанбаатар хот

Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.9-д заасан эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд албан татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлагыг хавсралт ёсоор баталсугай.

2. Албан татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг олон нийтэд сурталчлан таниулах, албан татварын хөнгөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгж нь үйл ажиллагаандаа дээрх шаардлага, стандартыг хангаагүй нь тогтоогдсон тохиолдолд энэ талаар тухай бүр татварын албанд мэдэгдэж ажиллахыг Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга /Э.Мөнхсүх/-д даалгасугай.

3. Албан татварын хөнгөлөлтөд хамрагдсан бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагааны статистик мэдээллийг нэгтгэн хагас жил тутам тайлагнах, татварын албатай тухай бүр мэдээлэл харилцан солилцож, гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга /Э.Мөнхсүх/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.


5. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/518 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

6. Энэ тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтэлсэн өдрөөс 2035 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдсүгэй.

САЙД



Т.МӨНХСАЙХАН



Эрүүл мэндийн сайдын 2025 оны
05 дугаар сарын 07-ны өдрийн
Ажиг дугаар тушаалын хавсралт

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН
ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ТӨСӨЛ,
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.9-д заасан албан татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартыг тодорхойлох, түүнд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэхүү шаардлага, стандартыг баримтална.

1.2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.9-д заасны дагуу хөнгөлөлтийг олгохдоо дараах зарчмыг баримтална:

- 1.2.1 нийгмийн хариуцлагад суурилсан, сайн дурын байх;
- 1.2.2 ил тод, нээлттэй байх;
- 1.2.3 баримт, нотолгоонд үндэслэсэн байх;
- 1.2.4 хүний эрүүл мэндийг дэмжсэн байх;
- 1.2.5 ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.


Хоёр. Албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл,
үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага

2.1.Хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.татвар төлөгчийн нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрийн эсхүл өөр хуулийн этгээдийн элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан бодитой хөрөнгө оруулалт байх;

2.1.2.татвар төлөгчийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8.1, 8.5-д заасан үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй байх;

2.1.3. татвар төлөгч бусад этгээдэд хөрөнгө оруулалт хийх тохиолдолд тухайн этгээдтэй төсөл, үйл ажиллагаанд нь хөрөнгө оруулалт хийх гэрээ байгуулж, гэрээг нотариатаар гэрчлүүлж, хөрөнгө оруулалт авч буй талын санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх;



2.1.4. шинээр барьж байгуулах, засварлах, өргөтгөх, тохижилт хийх үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлага, онцлогт нийцсэн түгээмэл загвар бүхий зураг төсөлтэй байхаас гадна, тэгш хүртээмжтэй ашиглах боломжтой байх;

2.1.5. хөрөнгө оруулалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа БНБД, СНиП, БД, MNS-ийн шаардлагыг хангах.

2.2. Хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, хандив нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1. хариу төлбөргүй шилжүүлсэн мөнгөн болон биет хөрөнгө байх;

2.2.2. санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авч байгаа этгээд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хандив олгох татвар төлөгчтэй харилцан хамааралгүй байх;

2.2.3. Иргэний хуульд заасныг баримтлан санхүүгийн дэмжлэг, хандивын тусгай зориулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9-д нийцүүлэн тусгасан гэрээ байгуулж, гэрээг нотариатаар гэрчлүүлсэн байх;

2.2.4. санхүүгийн дэмжлэг, хандив олгосон болон хүлээн авсан этгээд нь тухайн санхүүгийн дэмжлэг, хандивыг энэхүү шаардлагын 2.2.3-т заасан гэрээнд тусгасан зориулалтын дагуу тухайн тайлант хугацаанд зарцуулсан гэдгийг хүлээн зөвшөөрч, гэрээг цуцлах болон татгалзахгүй тухайгаа илэрхийлсэн акт үйлдэж, нотариатаар гэрчлүүлсэн байх;

2.2.5. санхүүгийн дэмжлэг, хандивын зардал нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх.


2.3. Энэхүү нийтлэг шаардлагын 2.1, 2.2-т заасан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.1, 13.1.3, 13.1.4, 13.1.5-д заасан хасагдах зардлын шаардлагыг хангасан байна.

2.4. Бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаа нь хавсралтад /Хүснэгт 1/ заасан шаардлага, стандартыг хангасан байна.

Гурав. Албан татварын хөнгөлөлт эдлэх
бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаа

3.1. Албан татварын хөнгөлөлт эдлэх төсөл, арга хэмжээ нь дараах төрөлтэй байна. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө оруулалт;

3.1.1 эрүүл мэндийн байгууллагын барилга, байгууламж барих, өргөтгөх, засварлах, тохижуулах;



ХҮСНЭГТ 1
БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ТӨСӨЛ,ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ
БУСАД ШААРДЛАГА

№	Татварын хөнгөлөлт олгох чиглэл	Зорилго, үндэслэл	Стандарт, журам	Ерөнхий шаардлага	Тусгай шаардлага	Тайлбар
3.1.1. Эрүүл мэндийн байгууллагын барилга, байгууламж барих, өргөтгөх, засварлах, тохижуулах						
1.	Эрүүл мэндийн байгууллагын барилга, байгууламж барих	Хангайн бүсийн эрүүл мэндийн ухааны Олон Улсын сувилал (эмнэлэг)-ийн барилга, байгууламж барих Монгол Улсын 2050 урт хугацааны бодлогод 2.2.23; Монгол Улсыг 2021-2025 онд хөгжлүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.2.3; Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 3.1.13. зорилт	Монголын уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5700:2020 Уламжлалт эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага MNS 5524-3:2015	Хангайн бүсийн хүн амд Уламжлалт анагаах ухааны аргаар нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх, гадаад улсад Монголын уламжлалт анагаах ухааныг сурталчлан таниулах, эрүүл мэндийн аялал жуулчлалыг эх орондоо татахад чиглэсэн сувилал байгуулах	Эмнэлгийн тохируулгад орчныг бүрдүүлсэн, уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээнд шаардлагатай нэмэлт тоноглол хийсэн байх, Монголын уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5700:2020 (тус стандартын норматив ишлэлд туссан стандартуудад нийцсэн байх	Уламжлалт анагаах ухааны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
2.	Эрүүл мэндийн байгууллагын барилга, байгууламж барих, өргөтгөх (Хавдар судлалын үндэсний төв-2-ын барилга)	Алсын хараа 2050, Зорилт 2.2.7, 9.1 Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2.3.1, 2.3.2	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6330:2017 Цацрагийн хамгаалалт: Цөмийн цацрагийн тунгийн зөвшөөрөгдөх хэмжээ. MNS 5631:2006	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг хангасан байх.	Цацрагийн хамгаалалтын стандартыг хангасан байх	-
3.	Эрүүл мэндийн байгууллагын барилга, байгууламж барих, өргөтгөх,	2.1.Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо,	Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх БНБД 31-22-21, Барилга байгууламжийн зураг төсөл БНБД 3.01-06-90, Эмнэлгийн барилга БД 31-115-12, Нэгдсэн эмнэлгийн	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг хангасан байх.		



3.	Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төвийн лаборатори, тоног төхөөрөмж	Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах чиглэлээр гадаад улс руу зорчих урсгалыг бууруулж, эх орондоо шинэ технологиудыг нэвтрүүлж, хүлээгдэл чирэгдэл бууруулах	Анагаах ухааны лаборатори. Хэмжлийн эталон лабораторид тавих шаардлага MNS ISO 15195:2011 Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага MNS 5530:2014 Эрүүл мэндийн лаборатори-Чанар ба чадавхид тавих шаардлага MNS ISO 15189:2015		Техникийн тодорхойлолт, сертификат, холбогдох мэдээлэл	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан байх
4.	Эмчилгээ оношилгоонд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, шинэ дэвшилтэд шинэ технологи нэвтрүүлэх	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 6330:2017 Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5095:2017 Өрхийн эрүүл мэндийн төвийн MNS 5292:2017 Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйлчилгээ MNS 5081: 2013	Эмчилгээ оношилгооны удирдамж, заавартай нийцсэн байх	Техникийн тодорхойлолт, сертификат, холбогдох мэдээлэл	Тухайн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаатай гэрээ байгуулж хүлээлгэн өгсөн байх
5.	Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрийн тоног төхөөрөмж	Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг бууруулах, дэвшилтэд технологи нэвтрүүлэх	Эм үйлдвэрлэлийн зохистой дадал 5524:2014 Уламжлалт эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага MNS 5524-3:2015	Олон улсын шаардлага хангасан байх	Техникийн тодорхойлолт, сертификат, холбогдох мэдээлэл	Тухайн эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэгчтэй гэрээ байгуулж хүлээлгэн өгсөн байх
3.1.5. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг сайжруулах						
1.	Шинээр баригдах, засварлах анхан шатны эмнэлгийн байгууллагын барилга, гадна талбайн тохижилт	Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэх зорилгоор анхан шатны тусламж, үйлчилгээний сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн хүртээмжийг нэмэгдүүлэх	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн MNS 5081:2013 стандарт Өрхийн эрүүл мэндийн төвийн MNS 5292:2017 стандарт Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар хавсралт "Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх барилгын норм, дүрэм"	Эмнэлгийн зориулалттай өрөө тасалгаанд тавигдах төлөвлөлт, ус, дулааны хангамж, эрүүл ахуйн шаардлага	Технологи, эрүүл ахуйн шаардлага	Сум, тосгоны барилгыг бүртгэлийн хүлээлгэн өгсөн байх ХҮҮЛЭЭР ҮНЭН ТНБА, туслах (Албан тушаалын нэр) Д. Дорж-түвшин (гарын үсэг) (гарын үсгийн тайлбар) 2025 оны 05 дугаар сарын 14

	засварлах, тохижуулах	эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн яаралтай тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	бүтэц, үйл ажиллагаа MNS 6330:2017, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 6330:2017, Клиникийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6673:2017, Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага MNS 6392:2013, Галын аюулгүй байдал MNS 4244:1994, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зам, хөтөч налуу шат MNS 6056:2003, 6005:2009		
			3.1.2. Эмнэлгийн барилгын гадна талбайн тохижилт хийх		
1.	Эмнэлгийн барилгын гадна талбайн тохижилт хийх	2.1.12. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх бүрдүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зам, хөтөч налуу шат MNS 6056:2003, 6005:2009, Барилгын орчны тохижилтын ажил БНБД 3.01.06-90	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг хангасан байх.	
			3.1.3. Эмнэлгийн хэрэгслээр хангах		
1.	Эрүүл мэндийн лабораторийн чанарын гадаад үнэлгээний тоног төхөөрөмж, тохиргооны материал, урвалж, оношлуураар хангах	Лабораторийн шинжилгээний сайжирч иргэдийн шинжилгээний хариуны зэрүүг арилгах	Анагаах ухааны лаборатори. Хэмжлийн эталон лабораторид тавих шаардлага MNS ISO 15195:2011 ISO/IEC Ур чадварын сорилын стандарт MNS ISO 15189:2024 "Эрүүл мэндийн лаборатори -Чанар, чадавхид тавих шаардлага"	ISO гэрчилгээ Чанарын баталгаажилтын гэрчилгээ	Аймаг орон нутгийн болон лавлагаа шатлалын лабораторийн чанарын гадаад үнэлгээг зохих байгуулсан (Албан тушаалын нэр) ХҮҮЛБАР БҮТЭН 2025 оны 05 дугаар сарын 14

Үйлдвэрлэгчийн гэрчилгээ
 Бүртгэлийн дугаар
 ТНСА
 (Албан тушаалын нэр)
ХҮҮЛБАР БҮТЭН
 2025 оны 05 дугаар сарын 14

(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)
 2025 оны 05 дугаар сарын 14

3.1.4 Эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах

	Монгол уламжлалт анагаах ухааны эмийн үйлдвэрүүдийн GMP шаардлагыг хангахад шаардлагатай тоног төхөөрөмж, барилгын материалаар хангах	Монгол эмийн нэмэгдүүлж дотоодын нийт бүтээгдэхүүний 1%-ийг бүрдүүлэх Монгол Улс "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.23.-ийг хэрэгжүүлэх	Монгол уламжлалт эмийн экспортыг нэмэгдүүлж дотоодын нийт бүтээгдэхүүний 1%-ийг бүрдүүлэх Монгол Улс "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.23.-ийг хэрэгжүүлэх	Уламжлалт эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага MNS 5524-3:2015, Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага MNS 5530:2014	Монгол эмийн үйлдвэрүүд GMP-н шаардлага хангасан байна	Техникийн тодорхойлолт, сертификац, холбогдох мэдээлэл	Монгол уламжлалт анагаах ухааны эмийн үйлдвэрүүдийг GMP шалдлага хангагдах, уламжлалт эмийн экспорт нэмэгдэх.
1.	Хавдрын тусламж, үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж (жагсаалтаар)	Алсын хараа 2050, Зорилт 2.2.7, 9.1 3Г-ын үйл ажиллагааны хөтөлбөр 2.3.1, 2.3.2	Алсын хараа 2050, Зорилт 2.2.7, 9.1 3Г-ын үйл ажиллагааны хөтөлбөр 2.3.1, 2.3.2	Хорт хавдрын эдэд байгенийн идэвхжилтийг тодорхойлох бодит цагийн полимеразын гинжин урвалын (БЦ-ПГУ) шинжилгээний арга MNS 6791:2019 Хорт хавдрын өвөрмөц уургийг тодорхойлох фермент холбоот эсрэг биеийн урвалын (ФХЭБУ) шинжилгээний арга MNS 6792:2019 Хорт хавдрын эдэд байгенийг тодорхойлох эх төрхөөр нь эрлийзжүүлэх туяаруулах (ЭТЭТ) шинжилгээний арга MNS 6793:2019 Хорт хавдрын эдэд байгенийг тодорхойлох эх төрхөөр нь эрлийзжүүлэх өнгөжүүлэх (ЭТӨӨ) шинжилгээний арга MNS 6794:2019 Хорт хавдрын эдэд байгенийн хувьсамжийг тодорхойлох өндөр нарийвчлалт хайлалтын шинжилгээний арга MNS 6795:2019 Хорт хавдрын эдэд байгенийг тодорхойлох иммуногистохимийн шинжилгээний арга MNS 6796:2019	Олон улсын чанарын шаардлага хангасан байна.	Мэргэжилтний гаргасан техникийн тодорхойлолтын дагуу	Хавдрын тусламж, үйлчилгээ, ХСҮТ-2, туяа эмчилгээний төвд шаардлагатай тоног төхөөрөмж

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 20.....
ХҮҮЛБАР ҮНЭН
715 А. Тусгай
(Албан тушаалын нэр)
А. Дунзаяа
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)
2025 онь 05 дугаар сарын 14

3.1.6. Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээг сайжруулах

1.	Хорт хавдрын системийн эмчилгээний эмийг нэг эх үүсвэрээс худалдан авах	Алсын хараа 2050, Зорилт 2.2.7, 9.1 ЗГ-ын ажиллагааны хөтөлбөр 2.3.1, 2.3.2	Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага MNS 5530:2014	Олон улсын чанарын шаардлага хангасан, ДЭМБ-ын эмийн хатуу зохицуулалттай орны	IOS, GMP
----	---	---	---	--	----------

3.1.7. Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг дэмжих

					Засгийн газрын 2001 оны 67 дугаар тогтоолоор баталсан "Сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай ажил, үйлчилгээний жагсаалт, тарилгын товлот"-ын 3 дугаар хавсралтын 2 дахь хэсэг:
1.	Эрүүл мэндийг хамгаалах	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтыг дэмжих	Дархлаажуулалтын тухай хууль 7.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн ажиллагчдыг сэргийлэх тарилгад бүрэн хамруулах үүрэг хүлээнэ.	Сайн дурын дархлаажуулалтыг дэмжих	Сум, дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргатай гэрээ байгуулж, хүлээлгэн өгсөн байх

ХАНГААХ ҮНЭН
 2025 оны 05 дугаар сарын 04
 (гарын үсэг/гарын үсгийн тайлалт)

					дурын дархлаажуулалтад хамруулах	
3.1.8. Судалгаа боловсруулалт, технологи, инновацыг сайжруулах						
1.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх инноваци, технологи	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинэ технологи нэвтрүүлэх замаар тусламж үйлчилгээг сайжруулах	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд технологийн үнэлгээ хийх арга, аргачлалын журам	Эмчилгээ, оношилгооны зааврыг орчин нотолгоонд суурилаж боловсруулах	Мэргэжлийн эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлсэн байх Монгол Улсын эрүүл мэндийн үндэсний тооцоо судалгааны тайлан	Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
2.	Эрүүл мэндийн технологи дамжуулалт	Оношилгоо, эмчилгээний технологи дамжуулалт, инноваци нэвтрүүлэлт хийх	Технологи дамжуулах тухай хуулийг мөрдсөн байх	Технологи дамжуулах тухай хуулийг мөрдсөн байх	Технологи дамжуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх	Эрүүл мэндийн байгууллага (ЭЭХХЗГ)-тай гэрээ байгуулж, хүлээлгэн өгсөн байх
3.	Эрүүл мэндийн судалгаа хөгжүүлэлт	Эрүүл судалгаа хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалт, тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх	Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөх	Эрүүл мэндийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хөрөнгө оруулах, судлаачдад зориулсан тэтгэлэг бий болгон зарлах	Хууль тогтоомжид нийцсэн байх	
4.	Инновацийг хөгжүүлэх	Өргөн хүнсний бүтээгдэхүүнийг аминдэм, эрдэс бодисоор баяжуулах	Баяжуулсан хүнсний тухай хууль, түүнийг даган мөрдөх журам	Мэргэжлийн байгууллага, судлаачидтай хамтрах	Эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН БҮРТЭЛИЙН ДҮГНЭЛТ ХҮҮЛБЭР ҮНЭН 2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 14

--- о0о ---

(Албан тушаалын нэр)
Д. Доржтүвшин
(гарын үсэг) (гарын үсгийн тайлаг)
2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 14